



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар АН/16

Батширээт сум

Ойд явуулах үйл ажиллагааны хоригийг
цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.14 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын нутаг дэвсгэрт хур бороо орж, чийгшил ихтэй болж ой хээрийн түймрийн эрсдэлгүй орчин бүрдсэн тул ойд явуулах үйл ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хэвийн үргэлжлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойд явуулж буй үйл ажиллагаанд зохих хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин хяналтын Улсын байцаагч (Б.Мөнх-Очир), бүх шатны байгаль хамгаалагчид сум Дундын Ойн ангийн дарга (Г.Гантуяа) нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Бүдханд)-д даалгасугай.

4. Дээрх шийдвэртэй холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/37 тоот захирамжаар ойд явуулах үйл ажиллагаанд тавьсан хоригийг цуцалсугай.

ЗАСАГ ДАРГА В. АЛТАНГЭРЭЛ



20250605